



ТӨВ АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
XI Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 80

Эрдэнэ-Уул

Хяналтын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах ажлын хэсэгт хяналт тавих чиг үүрэг бүхий “Хяналтын хороо”-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга:

С.Зоригтбаатар /Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч /

Гишүүд:

Г.Гантуяа /Санхүү албаны дарга/

мэргэжилтэн/

/Аймгийн хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан

С.Баярсайхан /Малчны бүлгийн төлөөлөл/

Г.Гантөмөр / Иргэний төлөөлөл /

2.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах зээл олгох журамд заасан шалгуур хангасан хоршоо, иргэн болон Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд шуурхай хүргэж, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг ил тод, нээлттэй шалгаруулж, үр дүнтэй хэрэгжүүлж зохион байгуулж ажиллахыг хорооны нарийн бичгийн дарга (Г.Энхтамир)-д үүрэг болгосугай.

3.Шалгарсан төслийн хэрэгжилтийг хангах, зээлийн эргэн төлөлт, гэрээний үүргийг биелүүлэх эсэхэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА  Т.БААСАНСҮРЭН

